

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ДАГАВРЫН ОНЦЛОГ

Сун Бён Гү*

1. Оршил

Монгол хэлэнд залгаврыг угтвар ба дагавар гэж хуваах боловч монгол хэлэнд угтвар байхгүй бөгөөд зөвхөн дагавар байдаг.

БНМАУ-ын ШУА (1966:71)-аас “Залгавар гэдэг нь үгэнд үгийн үндсээс бусад бүх хэлбэрийг хэлнэ” гэжээ. Залгавар нь шинэ үг үүсгэж байна уу эсвэл тухайн үг нь өөр үг ба өгүүлбэртэй ямар холбоотой болохыг илэрхийлж байгаагаас шалтгаалан үг бүтээх дагавар ба үг хувилгах дагавар гэж хуваадаг. Ерөнхий бидний ойлголтоор монгол хэлний үг бүтээх дагавар нь ‘derivational suffix’-ийг илэрхийлэх ба үг хувилгах дагавар нь ‘inflectional suffix’-ийг илэрхийлнэ. Гэвч монгол хэлэнд үг хувилгах дагавар нь ердийн үед нөхцөл хэмээх ухагдахуунаар дуудагдах тул монгол хэлний дагаврыг зөвхөн үг бүтээх дагавар гэж үзэж болно. Монгол хэл шинжлэлийн эрдэмтэд дагаврын тухай ойлголт ба онцлогийн талаар дурдсан байх нь олонтой ч тэрхүү онцлогийг нөхцөлөөс ялган тодорхойлж өгсөн байх нь төдийлөн байхгүй байна. Тиймээс энэхүү судалгааны ажилд Bauer(1983:33)-т тавигдсан ‘derivational suffix’ ба ‘inflectional suffix’-ийн ялгааг ашиглан монгол хэлний дагаврын онцлогийг нөхцөлтэй харьцуулан нарийвчлан судлахаар зорив. Түүнчлэн үүнийг монгол хэлний дагаврыг үүсгэх үндсэн зарчмаар авч үзэн дагаврын жагсаалтыг гаргахаар зорилоо.

2. Дагаврын онцлог

Нэгдүгээрт, дагавар нь шинэ үг үүсгэх боловч нөхцөл нь шинэ үг бүтээхгүй. (1а.)-д дурдсан жишээнд үйл үгэнд дагавар залгагдаж үйл үгээс огт өөр шинэ үг бүтээх боловч (1б.)-ийн жишээнд үйл үгэнд үйлийн цаг илэрхийлэх нөхцөл залгагдан үйл үгэнд цаг хугацааны утгыг нэмсэн төдий болохоос үйл үгийн үндсэн утгыг өөрчлөхгүй байгаа нь харагдаж байна.

- (1) а. [сур-]v + гч → [сурагч]n
б. [сур-]v + -на → [сурна]v

* МУИС-ийн МХСС-ийн докторант

Хоёрдугаарт, дагавар нь үгийн үндсээс үгсийн аймаг үүсгэн өөрчилж болдог боловч нөхцөл нь өөрчлөх боломжгүй. (1а.)-ын жишээнээс харахад дагавар залгагдаж үйл үгээс нэр үг рүү шилжиж үгсийн аймаг өөрчлөгдсөн боловч нөхцөл залгагдсан (1б.)-ийн жишээнд үгсийн аймаг өөрчлөгдөөгүй байна. Үүнтэй нэгэн адил нөхцөл нь ямар ч тохиолдолд үгсийн аймгийг өөрчлөх боломжгүй юм.

Гуравдугаарт, дагавар нь зарим үгэнд залгагдаж үг бүтээж чаддаг боловч залгагдах боломжгүй тохиолдол бас байна. Харин нөхцөл нь ямар ч үгэнд залгагдаж үг бүтээх чадалтай байдаг. Доорхи <хүснэгт>-ээс харахад “-чин” гэсэн дагавар нь ямар үг байхаас шалтгаалж зарим үгэнд залгагдах боломжгүй байхад харин эсрэгээр “-аар, -саар” гэсэн тийн ялгалын нөхцөл нь ямар ч үгэнд залгагдаж байна..

<Хүснэгт>

	мод	мал	ам	нар				
дагавар	-чин	модчин		малчин	*	*		
Үйлдэхийн тийн ялгалын нөхцөл				-аар ⁴	модоор	малаар	амаар	нараар
Гарахын тийн ялгалын нөхцөл				-аас ⁴	модноос	малаас	амнаас	нарнаас

Дөрөвдүгээрт, дагавар нь нөхцөлийг бодвол үгийн үндэс-т д илүү ойрхон байрлана. Өөрөөр хэлбэл дагавар нь нөхцөлийн ард илрэх тохиолдол огт байхгүй гэсэн үг юм.

- (2) а. сургуулиас : сург- + -ууль + -аас
 үгийн үндэс + дагавар + нөхцөл
 б. * сургаасууль : сург + аас + ууль
 Үгийн үндэс + нөхцөл + дагавар

(2а.)-аас “сургуулиас” гэсэн үгийг авч үзэхэд ‘үгийн үндэс + дагавар + нөхцөл’-өөс бүрдэж байна. Үүнтэй адил дагавар нь үргэлж нөхцөлийн өмнө илэрнэ. Гэвч (2б.)-ээс харахад нөхцөл нь дагаврын өмнө байрлах үед үгийн утга алдагдаж байгаа бөгөөд энэ нь нөхцөл дагаврын өмнө байрлах боломжгүй болохыг илэрхийлж байна.

Тавдугаарт, дагавар нь үгийн үндэс дээр үгийн сангийн утгыг нэмж өгөх боловч нөхцөл нь зөвхөн хэлзүйн утгыг нэмж өгнө. Жишээ нь дээрх <хүснэгт>-т ‘модчин’, ‘малчин’ гэсэн үгийг авч үзэхэд ‘мод’, ‘мал’ гэсэн үгэнд дагавар ‘-чин’ залгагдан үгийн үндэс дээр үгийн сангийн утгыг нэмж, шинэ үг бүтээжээ. Гэвч ‘модоор’, ‘малаас’ гэсэн үгийн хувьд ‘мод’, ‘мал’-д үйлдэхийн тийн ялгалын нөхцөл ‘-оор’ болон гарахын тийн ялгалын нөхцөл ‘-аас’-ийг залгахад үгийн үндэст хэлзүйн утгыг нэмж өгсөн байгааг харж болно.

Зургадугаарт, нөхцөл бол утга нь тогтмол байдаг. Харин дагавар бол утга нь тогтвортой бус байдаг.

- (3) а. өлгө- өлгүүр, түлх- түлхүүр
 б. дэлгэх- дэлгүүр, гулг- гулгуур
 в. өлг- өлгөхөөр, түлх- түлхэхээр

г. дэлг- дэлгэхээр, гулг- гулгахаар

Дээрхи (3а.)-д ‘өлгүүр’, ‘түлхүүр’-т залгасан дагавар болох ‘-уур2’ ба (3б.)-д ‘дэлгүүр’, ‘гулгуур’-т залгасан дагавар болох ‘-уур2’-ийн утга нь өөр юм. (3а.)-ийн ‘уур2’ нь ямар нэгэн багажийн нэрийг илэрхийлж байхад (3б.)-ийн ‘-уур2’ нь газрын нэрийг илэрхийлж байна.

Долдугаарт, ерөнхийдөө нөхцөлийн утга нь зарчмын хувьд таамаглагдаж байхад эсрэгээр дагаврын утга нь зарчмын хувьд таамаглагдахгүй байх хандлагатай.

- (4) а. мод-модоор, мал-малаар, ам-амаар
б. оюу(н)-оюутан, эрдэм-эрдэмтэн, жигүүр-жигүүртэн

Дээрхи (4а.)-ын хувьд нэр үгийн үгийн үндэс дээр үйлдэхийн тийн ялгалын нөхцөл ‘-оор’ залгагдан утга нь зарчмын хувьд гарч ирж байна. Учир нь эдгээр үг ‘-аар’ гэх үйлдэхийн тийн ялгалаас өөр онцлог утгыг гаргаж ирэх тохиолдол байхгүй. Гэвч (4б.)-ийн хувьд ‘оюутан’, ‘эрдэмтэн’, ‘жигүүртэн’ нь (4а.)-тай адил зарчмын утгыг гаргахгүй байна. ‘-тан’ гэсэн дагаврын утга нь голдуу “ямар нэгэн юмтай хүн, амьтан” юм. Тиймээс дагаврын энэхүү утга болон үгийн үндсэн утгаас авч үзвэл утга ерөнхийдөө гарч ирж болно. ‘оюутан’ нь ‘оюу(н)’-тай хүн гэж үзвэл утгын хувьд ерөнхийдөө асуудал байхгүй мэт байна. Гэвч ‘оюу(н)’-тай хүн бүгд ‘оюутан’ гэх боломжгүй юм. ‘оюутан’-ы зөв утга нь “оюун ухаантай хүний хувьд их сургуульд явж дээд зэргийн оюун ухааны эрдэмд суралцаж байгаа хүн”-ийг хэлнэ. Эндээс их сургуульд явна гэсэн утга нь үгийн үндсэн утгаасаа ч дагаврын утгаасаа ч зарчмын хувьд таамаглах боломжгүй утга юм.

Наймдугаарт, дагавраас үгийн үндсэн утга туйлын хязгаарлагдах боловч нөхцөлөөс үгийн үндсэн утга хязгаарлагдахгүй юм.

Жишээ нь ‘сууц’ гэдэг үг нь ‘суу-’(амьдрах, суух) гэсэн хоёр утгатай боловч ‘амьдрах’ гэдэг утгаар хязгаарлагдаж байгааг харж болно. Гэвч ‘суу-’(амьдрах, суух)гэдэгт одоо цагийн нөхцөл ‘-на’ залгагдан ‘сууна’ гэсэн үг үүссэн тохиолдолд үгийн үндсэн утгатай хамааралгүйгээр ‘амьдарна’ гэсэн утгаас гадна ‘сууна’ гэдэг утга бас байна. Үүнээс харахад нөхцөл нь үгийн үндэстэй бүх утгаар холбогдоно.

3. Дүгнэлт

Өнөөг хүртэлх монгол хэлний дагаврын жагсаалт нь тэрхүү үүсгэгдэх зарчим тодорхой бус. Энэхүү жагсаалтанд дагавар биш нөхцөлүүд хамрагдсан тохиолдол гарч байгаагаас үүдэн эрдэмтэд харилцан өөр өөр жагсаалтыг гарган ирэх шалтгаан болсоор ирсэн. Тиймээс дээр өгүүлсэн нөхцөлөөс ялгагдаж буй дагаврын онцлог талыг цаашид монгол хэлний дагаврын жагсаалтыг гаргах гол зарчим болгон ялгаж байхаар тусгав.

Summary

The purpose of this study is to build a systematic and precise noun-derivative suffix list in modern Mongolian language according to coherent classification standard, and to provide exact examples for the list. In that language, derivative suffixes have mostly been handled in the word-formation section in morphology to date. Furthermore, they are just arranged by a part of speech of base. There is no systematic list even about the most fundamental types of derivative suffixes, and few studies have ever paid attention to that. To delve into derivative suffix, it is most urgently needed to set up accurate classification criteria and prepare its list.

Ном зүй

- БНМАУ-ын ШУА (1966) Орчин цагийн Монгол хэлзүй, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар.
- Болд,Л. (1986) Орчин цагийн Монгол хэлний дагавар, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар.
- Лувсанвандан,Ш. (1968) Орчин цагийн Монгол хэлний бүтэц, Шинжлэх Ухааны Академи, Улаанбаатар.
- Лувсанжав,Ч. (1971) A Contrastive Analysis of the Morphological Structure of Words in the Mongolian and English Languages, Moscow.
- Өнөрбаян,Ц. (1994) Орчин цагийн Монгол хэлний үг зүй, УБИС, Улаанбаатар.
(2000) Орчин цагийн Монгол хэлний үйл үг бүтэх ёс, Улаанбаатар.
- Aronoff, M (1973) Word Formation in Generative Grammar, MIT Press, Cambridge, Massachusetts.
- Bauer,L (1983) English Word-formation, Cambridge University Press, Cambridge.
- Hans-Peter Vietze (1976) Рьсклдуфигес Wцrterbuch der mongolischen Sprache, VEB Verlag Enzyklopedie Leipzig.
- Rita Kullmann & D. Tserenpil (1996) Mongolian Grammar, Ulaanbaatar.
- Street, John Charles (1963) Khalkha structure. Uralic and Altaic Series 24. Bloomington: Researcher Center in Anthropology, Folklore and Linguistics. Indiana University.
- 강 신(1997) 현대몽골어 품사분류체계에 관하여, 몽골학 5 호, 한국몽골학회.
- 송철의(1992) 국어의 파생어 형성 연구, 국어학 총서 18, 태학사.
- 清格尔泰(1992) 蒙古語語法, 內蒙古人民出版社, 呼和浩特.